

**"МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР" ОНӨТҮГ
АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ**

А. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Байгууллагын нэр	2. Нэгжийн нэр	
Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ-азар	Тохижилт үйлчилгээний алба	
3. Ажлын байрны нэр	3.1. Ангилал	3.2. Зэрэглэл
Жолооч	ТҮ	3-5
4. Ажлын байрыг шууд харьяалагдах албан тушаалын нэр:	5. Шууд харьяалан удирдах албан тушаал	
Газрын дарга Орлогч дарга Ахлах мэргэжилтэн Инженер		

Б. ЧИГ ҮҮРЭГ

1. Ажлын байрны зорилго	"Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр хангах машин, техник тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хариуцах
2. Ажлын байрны үндсэн зорилт	2.1. Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, үр дүн:
1. Байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр хангах, машин, техник тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хариуцах	1. Машин, техник тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал хангагдсан, байгууллагын үйл ажиллагаа хэвийн явуулах нөхцөл бүрдсэн байна.

3. Ажлын байрны гол үйл ажиллагаа	3.1. Хугацаа (хувиар)
Ажлын байрны үндсэн зорилтын хүрээнд: - Өөрийн хариуцан эзэмшиж байгаа тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хариуцаж, засвар үйлчилгээг нэн даруй хийлгэж байх. - Замын хөдөлгөөнд холбогдох дүрэм, журмыг баримтлан оролцох - Сар бүрийн шатахууны тооцоог гаргаж, жолоочийн замын хуудсыг хөтлөн тухай бүрд нь захиргаа санхүүгийн албанд хүргүүлэх - Байгууллагын данстай тээврийн хэрэгслийг ажил дуусмагц автогражид байрлуулж, хариуцсан сахиулд хүлээлгэн өгөх - Автомашинны эвдрэл гэмтэл гарсан үед техникийн комисст мэдэгдэж дүгнэлт гаргуулан нэн даруй арга хэмжээг авах - Тохижилтын ажил үйлчилгээнд шаардлагатай эд хөрөнгө, тоног төхөөрөмжийг заасан ажлын байранд зөөж тээвэрлэн хүргэх - Үндэсний их баяр наадам, бусад тэмдэглэлт баяр наадмын өдрүүдийн үйл ажиллагаа дуусмагц эд хөрөнгө, бараа материал, тоног төхөөрөмжийг зөөж тээвэрлэн агуулахад буцаан хураах - Өөрийн буруугаас шалтгаалан байгууллагын эд хөрөнгөнд хохирол учруулсан тохиолдолд хохирлыг эзэмшигч бүрэн хариуцах - Удирдах албан тушаалтнаар замын хуудас, шатахууны зарцуулалтад гарын үсэг зуруулан баталгаажуулж санхүүгийн тооцоог гарган захиргаа, санхүүгийн албанд гарган өгөх - Удирдах албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр тээврийн хэрэгслийг бусдад шилжүүлэх, хувийн хэрэгцээнд ашиглахыг хориглоно. - Баяр ёслолоор болон цаг үеийн шаардлагатай тохиолдолд уртасгасан цагаар ажиллах - Хүй долоон худгийн ажил үүргээс шалтгаалсан мэдээ мэдээллийг нэн даруй шуурхай зохион байгуулан ажиллах	90